



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 6/09

Хэрлэн сум

С.Сарангоог туршилтын  
хугацаагаар ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.1, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.4 дахь заалт, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 тогтоолын 10 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, аймгийн Засаг даргын 2023 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” Б/47 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, зохион байгуулалт хариуцсан ажилтнаар Сарантуяагийн Сарангоог 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс туршилтийн 3 сарын хугацаагаар томилсугай.

2.С.Сарангоод ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Н.Баярсайхан	Аж ахуйн тасгийн дарга
Гишүүд:	Х.Баярбаатар	Нягтлан бодогч
	С.Чулуунцэцэг	Нярав

3.С.Сарангоогийн сарын үндсэн цалинг ТҮ-7 зэрэглэлээр тогтоон, 1,053,000 (нэг сая тавин гурван мянга) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 3 хувиар тус тус тооцож олгохыг Нягтлан бодогч (Х.Баярбаатар)-д зөвшөөрсүгэй.2.

4.С.Сарангоогийн ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг ажил хүлээлцүүлэх комисс (Н.Баярсайхан)-т даалгасугай.

2.

5.Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг С.Сарангоод үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА